

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Бат-Очир Билгүүннاران
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
<p>1.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>							
1	Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах арга хэмжээг зохион байгуулсан байна.	ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах арга хэмжээг зохион байгуулсан байна.	2024 онд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 25 зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан	Зөвлөмж ирсэн тухай бүр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна.	Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсарлтаар баталсан Монгол Улсын Төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын IV.1.4.1-т заасан Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүдэд/-ний хүрээнд нийт 2025 оны байдлаар 19 төсөл арга хэмжээний зөвлөмж ирснээс 7 төсөл арга хэмжээний гэрээг эцэслэн байгуулсан. Мөн 2024 болон 2025 онд байгуулсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ гэрээний 31 нэмэлт, өөрчлөлтийг боловсруулан эрх бүхий албан тушаалтнуудаар зуруулан баталгаажуулсан.		
2	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ	Гүйцэтгэлийн явц, хувиар	2024 онд байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна.	Удирдлагаас хуваарилсан байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна.	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 187 албан бичиг цохогдсон бөгөөд яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах хариутай 166 албан бичгийг боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн байна. Тодруулбал Засгийн газрын тогтоолын төсөл, Хууль, тогтоомжийн төсөл, Захиргааны хэм хэмжээний актын төсөл зэрэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу саналыг тухай бүр хуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	95%

					хугацаанд хүргүүлж байна. Мөн удирдлагаас өгсөн үүргийн дагуу яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих бусад нэгжүүдийн боловсруулсан тушаал, шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянаж байна. Тодруулбал Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаартай тушаалаар батлагдсан "Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлуулсан. Тус журмын хавсралтаар дэмжлэг авах албан хаагчдын эхний жагсаалтыг батлах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамж, өргөдлийн загвар болон тогтвортой ажиллах гэрээг мөн батлуулсан болно.		
3	Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр төлөөлөх, нийтийн	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлсэн байх, хувиар	2024 онд Монгол Улсын ЗГ, болон ЭЗХЯ-ыг хариуцагчаар татсан эрүүгийн болон захиргааны хэрэг маргаанд төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажилласан.	Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/	1.Монгол Улсын Засгийн газар болон "Улаан дөл" ХХК-ийн хооронд байгуулагдсан ХОГ-2016/73/7-46-24 дугаартай "Ховд, Жаргалант, 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл"-ийн барих шилжүүлэх /ВТ/ концессын гэрээ"-ний дагуу нийт 168,653,460.0 төгрөгийг Эдийн засаг,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	<p>ашиг сонирхлыг хамгаалах</p>				<p>хөгжлийн яамнаас гаргуулах захиргааны хэрэгт итгэмжлэлээр төлөөлөн оролцож байгаа.</p> <p>2.Хил хязгааргүй алхам НҮТББ-ын нэхэмжлэлтэй "Үндэсний хөгжлийн газар болон Тахилт хайрхан транс ХХК нарын хооронд 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан "Тавантолгой-Манлай-Ханги" чиглэлийн авто замы төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ /500 сая доллар хүртэлх төсөвт өртөгтэй/-г цуцлуулах тухай шүүх хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцон анхан шатны шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон ба нэхэмжлэгчээс давж заалдах гомдол гаргасны дагуу шүүх гомдлыг хүлээн авч анхан шатны шүүхрүү буцаагаад байна.</p> <p>3.Худалдаа хөгжлийн банкны нэхэмжлэлтэй Дарханы төмөрлөгийн үйлдвэрт холбогдох 24.8 тэрбум төгрөгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт Бие даасан шаардлага гаргасан</p>		
--	---------------------------------	--	--	--	--	--	--

					<p>гуравдагч этгээдээр оролцох хүсэлт гарган гуравдагч этгээдээр томилогдон ажиллаж байна 4."Монгол улсын Эдийн засгийн хөгжлийн сайд, Зам тээврийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 26/69/75 дугаартай тушаалаар байгуулсан Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэлийг хянах ажлын хэсгийн гишүүд нь Энержи ресурс ХХК-д давуу байдал бий болгосон" гэх хэрэгт ЭХХШтХуулийн 8.1, 8.5 дугаар зүйлд зааснаар хохирогч, иргэний нэхэмжлэгчээр томилогдон ажиллаж байна. Одоогоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. 5. "Наанова грин энерги монголиа" ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа Маргаан шийдвэрлэх зөвлөлд холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон бөгөөд 2025.11.27-ны</p>		
--	--	--	--	--	--	--	--

					өдрийн урьдчилсан хэлэлцүүлгээр хариуцагч талаас хүсэлт гарган хэргийг түдгэлзүүлүүлсэн		
4	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Хуулийн хугацаанд мэдүүлсэн байх, хувиар	2024 онд албан хаагчид 100 хувь мэдүүлсэн	Хуулийн хугацаанд нийт албан хаагчид мэдүүлсэн байна. /100 хувь/	Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагын нийт 308 хүний хөрөнгө орлогын мэдүүлгийг 2025.02.15-нд Шинэчлэн гаргуулсан. Мөн 2025 оны байдлаар 141 албан хаагчдын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хуульд заасан хугацаанд хянуулсан болно. 2. Meduuleg.iaac.mn цахим систем, Эдийн засаг, хөгжлийн яамны веб сайт болон Shilendans.gov.mn цахим системүүдэд Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг тухай бүр бүртгэж байгаа болно. 3. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Нийтийн албан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>тушаалтны хориглолт хязгаарлалтыг танин мэдүүлэх зорилгоор Эрх бүхий албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газраас 3 удаагийн танхим, цахим хосолсон сургалтыг яамны албан хаагчдын дунд хийсэн болно. 4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/258 дугаар тушаалаар Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа "Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн", "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн", "Ургамал, газар тариалангийн хүрээлэн", "Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн", "Уламжлалт, анагаах ухаан, технологийн хүрээлэн", "Анагаах ухааны хүрээлэн"-ийн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд чанарын шаардлага хангаж байгаа эсэх төслийн үр дүн бодитой хэрэгжиж, хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх дээр хяналт тавих, авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль</p>		
--	--	--	--	--	--	--	--

					тогтоомжийг танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан харьяа байгууллагын нийт 500 гаруй албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг орсон.		
5	Яамнаас байгуулах гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, боловсруулах, дугаар олгох	Тухай бүр боловсруулсан, хяналт хэрэгжүүлсэн байдал, хувиар	2024 онд тухай бүр гэрээний төслийг боловсруулж, хяналт хэрэгжүүлж ажилласан.	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гэрээний төслүүдийн хууль зүйн үндэслэлийг тухай бүр хянаж дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна./ 100 хувь/ байна./100 хувь/	2025 оны эхний хагас жилийн байдлаар Эдийн засаг, хөгжлийн яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг боловсруулж, хянаж, нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно: 1. 2025 оны Гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн бөгөөд 2025 оны байдлаар 79 гэрээнд дугаар олгон баталгаажуулсан байна. Үүнээс - Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 21 аймгийн засаг дарга болон Нийслэлийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, - Төрийн албаны реформ-Бидний шийдэл" Төрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>албан хаагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл хэвлэн гаргах ажил гүйцэтгэх гэрээ, -</p> <p>Хуулийн төсөл боловсруулагчийн арга зүйн сургалт зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ - Аврагч спорт хорооны заалаар үйлчлүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ, - Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл арга хэмжээний Багц-1 "Биотехнологийн төвийн олигонуклеотид нийлэгжүүлэхэд шаардлагатай багаж, төхөөрөмж нийлүүлэх тендерийн гэрээ, - Австралийн холбооны улсын канберрагийн их сургуулийн оюутан болон албан байгууллага хоорондын гэрээ, - Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний ажил- гүйцэтгэх гэрээ, -</p> <p>ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын даргын зөвлөхтэй байгуулах зөвлөх үйлчилгээний гэрээ, -</p>		
--	--	--	--	--	---	--	--

					Дэлхийн банкны суурин төлөөлөгч Таехюн Ли болон бусад албан төлөөлөгчдийг хүлээн авч хэлэлцэх уулзалтын арга хэмжээний өдрийн хоолоор үйлчлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ, - Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим ашиглах үйлчилгээ үзүүлэх гэрээ, - Туушин зочид буудлын танхим ашиглах үйлчилгээ үзүүлэх гэрээ зэрэг нийт 20 гаруй гэрээний хууль зүйн үндэслэлийг хянасан 2. Мөн яамны хэмжээнд байгуулагдсан 2023, 2024 онд гэрээнүүдийг архивын нэгж үүсгэн Архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.		
6	Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах	Гүйцэтгэлийн явц, оролцоо, хувиар	-	Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна.	Салбарын хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах хууль төслийн ажлын хэсэгт орж ажилласан байна. Үүнд: 1. Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл 3. Эдийн засгийн эрх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>чөлөөний хууль /Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд заасны дагуу судалгааны ажлын даалгаварыг боловсруулсан/ 4. Мөн Монголын Хуульчдын холбоотой хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа байгууллагын ажилтнуудын дунд 2025.08.30-31-ны өдрүүдэд "Хуулийн төсөл боловсруулагчдын арга зүйн сургалт"-ыг зохион байгуулан 40 гаруй албан хаагчийг хамруулсан. 5.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох, Засгийн газарт эрх олгосон 46 хуулийн заалтын дагуу батлагдах хэм хэмжээ тогтоосон актуудын хэрэгжилтийг тодорхойлоход сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй 10, хуулийн хэрэгжилтийг хангаж Засгийн газрын тогтоол гарсан 27, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахаар холбогдох хэм хэмжээ тогтоосон актыг хууль тогтоомж, эрх</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>зүйн зохицуулалтыг судалж буй 6, журмын төслийг боловсруулан санал авч буй 1, Засгийн газар Улсын их хуралд өргөн барьж батлуулсан 2 зохицуулалт байна. Иймд сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Засгийн газраас батлагдан, хэрэгжиж байгаа хэм хэм тогтоосон актуудад, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн баталсан "Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж"-ийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дараах 10 журмыг бүхэлд нь хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг хуульд тусгах ажлыг зохион байгуулах саналыг хүргүүлсэн. Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам; Зөвшөөрлийн зөвлөлийн ажиллах журам;</p>		
--	--	--	--	--	--	--	--

				Хавсралт: 3 файл			
7	Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, яамны нэгжүүдийг авлигын эсрэг мэдээллээр хангана	Хэрэгжилтийн явц, хувиар	Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, албан хаагчдыг сургалтад хамруулсан.	Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргах, албан хаагчдыг сургалтад хамруулах /100 хувь/	Эдийн засаг, хөгжлийн яамны "2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлуулсан. Мөн яамны албан хаагчдад төлөвлөгөөг танилцуулах зорилгоор teams-д болон 1 давахрын "Шударга ёс хөгжил дэвшил 110" самбарт цаасан хэлбэрээр байршуулсан. Тус төлөвлөгөөнд туссан дараах ажлуудыг 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар хэрэгжүүлээд байна. 1. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг ажилуулж АТГ-аас холбогдох материалуудыг тухай бүр авч самбарыг шинэчилэн ажилласан. 2. Нийт албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>Хөрөнгө орлогын мэдүүлэг зэргийг хэрхэн мэдүүлэх талаах сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон. 3. Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Эдийн засаг, хөгжлийн яам түүний харьяа газруудын албан хаагчдад "АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙ ХОР ХӨНӨӨЛ" сэдвээр танхимын сургалтыг хийсэн. 4. Мөн төлөвлөгөөнд туссан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 14 мега төслийн талаар авлигатай тэмцэх газрын комиссаруудтай уулзан санал зөвлөмж солилцсон болно. 5. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтыг харьяа байгууллагуудын албан хаагчдыг мөн хамруулах байдлаар 2 дугаар сард цахимаар зохион байгуулсан. 6. Ил тод байдлыг сайжруулах зорилгоор яамны вэб сайтын ил тод мэдээллийн</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>хэсгийг шинэчлэн, Авлигатай тэмцэх газарт ил тод болгосон мэдээллийн жагсаалтыг гарган өгч хамтран ажилласан. 7.ЭЗХЯ-ны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3-т зааснаар авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, уриалах зорилго бүхий видео бичлэгийг 2025.12.03-ны өдөр цахим хуудаст байршуулсан.</p> <p>Хавсралт: 6 файл</p>		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан ажлын чиглэлээр хууль	Тухай бүр сургалт, хэлэлцүүлэгт	2024 онд хууль эрх зүйн мэдлэгээ	Хариуцсан ажлын чиглэлээр хууль	2025 оны байдлаар хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	100%

	эрх зүйн мэдлэг мэргэжлээ ахисан түвшин дээшлүүлэх	суух	дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан байна.	6 эрх зүйн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн ажилласан байх	хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрын хөтөлбөрт суралцаж байгаа 2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн сургалтад хамрагдсан. 3. Мөн Монголын Хуульчдын холбоотой хамтран "Хуулийн төсөл боловсруулагчийн арга зүйн сургалт"-ыг 2025 оны 08 дугаар сарын 30-31-ны өдөр зохион байгуулан, хамрагдсан. 4. Удирдлагын академиас цахимаар зохион байгуулсан "Авлигаас ангид төрийн алба" анхан шатны сургалтад хамрагдсан. 5. Компанийн засаглалын хөгжлийн төв, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран зохион байгуулсан "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн" нарт зориулсан, компанийн засаглалын богино хугацаат сургалтад хамрагдсан. 6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт /АЗ/-д	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	------	--	--	--	---	--

					оролцож, шалгалтад хамрагдан эрх авсан. Хавсралт: 1 файл		
2	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцох	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцох	2024 онд Гадаад болон дотоодын мэргэшүүлэх 3 сургалт, хэлэлцүүлэгт оролцсон.	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	1. Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос зохион байгуулсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-ийн танилцуулга хэлэлцүүлэгт хамрагдсан, 2. Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдсан. 3. Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах", 4. Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилт, 5. "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж", 6. Healthy is the new cool сэдвээр хэлэлцүүлэг, семинарт идэвхтэй хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дашням Ариунбилэг /...../

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Бат-Очир Билгүүннэран /...../

Огноо: 2025.12.15

